

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Б.БАТБОЛД

ДХИС-ийн Удирдлагын академийн магистрант, хошууч

А.АМГАЛАНБАЯР

ДХИС-ийн Хилийн албаны удирдлага, стратегийн профессорын багийн ахлах багш, дэд хурандаа

Товч агуулга: Нийгмийн хамгааллын тухай онолын ойлголт, Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын нийгмийн хамгааллын асуудлыг судлан, цаашид анхаарах зарим санал дэвшүүлэхийг зорилоо.

Түлхүүр үгс: Нийгмийн хамгаалал, Хил хамгаалах байгууллагын алба хаагчид, өнөөгийн байдал, анхаарах асуудал.

Оршил

Хүний нийгмийн үүсэлтэй нэгэн зэрэг нийгмийн хамгааллын хэрэгцээ шаардлага бий болсон байдаг.

Нийгэм хөгжихийн хэрээр хүний хэрэгцээ шаардлага нарийсах бөгөөд энэ нь нийгмийн хамгааллын хүрээг зөвхөн хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд үзүүлэх тусалцаа төдийгөөр хязгаарлаж болохгүй гэдэг нь орчин үед үүсч байгаа инфляц, ажилгүйдэл, ядуурал зэрэг нийгмийн зүгээс хүний амьдралд нөлөөлж дарамт ачаа болдог сөрөг үзэгдлүүд бий болж байгаагаар тодорхойлогдох ба энэ нь нөгөө талаар нийгмийн хамгааллын үүрэг, хамрах хүрээг нэмэгдүүлэх хөшүүрэг, шаардлага болж байдаг байна. Нийгмийн хөгжлийн үе шат бүрд өөр өөрийн онцлог бүхий нийгмийн хамгааллын тодорхой хэлбэрүүдийг /хөтөлбөр/ бий болгон хэрэгжүүлж ирсэн байдаг¹.

Үндсэн хэсэг

Нийгмийн хамгааллын тухай ерөнхий ойлголт

Хүй нэгдлийн нийгмийн үед хөдөлмөрийн чадваргүй, ахмадуудад хандсан нийгмийн хамгааллын шинжтэй арга нь зан заншил дээр

тулгуурласан байсан бол боолын нийгмийн үед ахмад настан, хөдөлмөрийн чадваргүй иргэд гэхээсээ илүү дайнд гавьяа үзүүлсэн дайчдад тусалцаа үзүүлэх хандлага давамгайлж, харин феодалын нийгмийн үед зөвхөн дан ганц хөгшид, хөдөлмөрийн чадваргүй иргэд гэхээсээ илүү гэр бүлийн хүрээнд анхаарах чиглэл бий болсон байдаг.

Англид 1911-1913 онуудад даатгалын иж бүрэн хуулиудыг батлан гаргасан ба даатгалын системийн онцлог нь даатгалын байгууллагын үйл ажиллагаанд даатгуулагч нарыг оролцуулдаг оршино. Даатгуулагчын нас хүйс, тэрчлэн авч байгаа цалингаас нийгмийн даатгалын хураамж хамаарч байхаар зохицуулсан ба цалин бага бол хураамж бага цалин өндөр бол хураамж их байх, эрэгтэй хүний төлөх хураамж эмэгтэй болон ажилд орж байгаа залуу хүнийхээс илүү их байх гэх мэтээр зохицуулсан байна. 1911 оны хуулиндаа даатгалын эрсдэл гэсэн ойлголтыг тодорхойлж өгсөнд энэ хуулийн ач холбогдол оршино.

Монгол Улс нь 1921 онд ардын хувьсгал ялсны дараа нийгмийн

¹ А.Амартайван. Хил хамгаалах байгууллагын албан хаагчдын нийгмийн хамгааллыг боловсронгуй болгох арга зам. Уб., 2015.

хамгааллын шинжтэй арга хэмжээг хэрэгжүүлэх үүднээс хэд хэдэн актыг батлан гаргасан байдаг. 1921-1940 онуудад нийгмийн хангамжийн зарим төрөл, хэлбэр бий болж үндэс суурь нь тавигдсан юм.¹

1925 батлагдсан "Аливаа хүчин үнэлэгчдийн дүрэм" болон түүнд орсон өөрчлөлтөөр /1930,1932,1933,1934 он/ тухайн үед биеийн хүчин үнэлж байгаа ажилчин, албан хаагчдын нийгмийн хангамжтай холбоотой нэгэн бүлэг "Аливаа хүчин үнэлэгчдэд өвчний зэрэг зовлон тохиолдоход арчлан хамгаалахын учир тусламжийн тухай" оруулан баталж, хэрэгжүүлж байсан ба хүчин үнэлэгчдийн дүрэмд, ажилчин албан хаагч өвдөх, хөдөлмөрийн чадвараа түр алдвал нэг сар хүртэл, жирэмсэн болох, хүүхэд төрүүлэхэд гурван сарын хугацаанд цалинг олгож байхаар заасан нь анх удаа, хөдөлмөрийн харилцаанд оролцогчдын нийгмийн хамгаалалтай холбоотой эрхийг баталгаажуулсан заалт болсон юм.

Монгол Улсын хувьд 1941-1960 он нь нийгэм хангамжийн хөгжлийн үе шатанд чухал байр суурь эзлэх бөгөөд энэ үед нийгэм хангамжийн систем, эрх зүй нь бүрэлдэн бий болсон гэж үздэг.²

Нийгмийн хамгааллын ойлголт, төрөл: Нийгмийн хамгаалал нь бодитойгоор оршин байгаа нийгмийн үзэгдэл болохын хувьд шинжлэх ухаанд суурилсан ойлголт болох ба түүний үнэ цэнэ нь нийтлэг үндсэн шинжийг хэрхэн зөв тодорхойлсноор илэрхийлэгдэнэ.

Улс орон бүрийн нийгэм эдийн засгийн хөгжил, улс төр засаглалын хэлбэр, үндэсний соёл, уламжлал зэргээс хамаарч нийгмийн хамгаалал, түүний хамрах хүрээ, зохицуулалт нь өөр өөр байх боловч

үүнээс үл хамааран зайлшгүй байх дагаж мөрдөх үндсэн хандлага байдгийг, түүний мөн чанарыг илэрхийлж байгаа шинж гэж үздэг байна. Үүнд:

Нэгдүгээрт: нийгмийн хамгааллын системээр дамжуулан нийгмийн бүтээгдхүүн, хуримтлалыг хуваарилах зохион байгуулалт-эрх зүйн арга механизмыг төр тогтоох:

Хоёрдугаарт: нийгмийн хамгааллын харилцааны төрөл, хэлбэр буюу туслалцаа олгох үндэслэлээр дамжуулан төр нь нийгмээс хамааралтай эрсдлийг \түүний төрлийг\ тогтоох:

Гуравдугаарт: эрх зүйн хэм хэмжээ болон гэрээний зохицуулалтаар дамжуулан, төр нь нийгмийн хамгааллын тусламж, дэмжлэгийг авах, хүртэх хүрээг тодорхойлох:

Дөрөвдүгээрт: тусламж, дэмжлэгийн төрөл, олгох нөхцөл, хэмжээг, тодорхойлох журмаар нийгмийн хамгааллын стандартыг тогтоох:

Нийгмийн хамгаалал гэсэн ойлголтын агуулга, онцлогийг авч үзэхээс өмнө нэршил, нэр томъёотой холбоотой асуудлыг авч үзэх нь зайлшгүй. 1950-иад оны сүүлээр бие даасан салбар эрх зүй болж, Монгол Улсын эрх зүйн системд байр сууриа эзэлсэн үеэс "Нийгэм хангамж" гэсэн нэр томъёогоор нэршиж ирсэн.³

Нийгмийн хамгааллын чиг үүрэг: Нийгмийн хамгааллын эдийн засгийн шинж нь төрөөс онцгой асуудал болох хүмүүсийн орлогын тэнцвэргүй байдал, хөдөлмөрийн ялгаатай нөхцөл байдлыг зохицуулах үед хамгийн чухал түлхүүр, багаж нь болж хэрэглэгдэнэ. Нийгмийн хамгааллын харилцаанд агуулагдаж байгаа үндсэн шинж нь эрх зүйн хэм хэмжээ, олон улсын болон дотоодын

¹ С.Энхцацрал, Нийгмийн хамгаалалын эрх зүйн лекцүүд. 2011 он., 1 хуудас.

² Ц.Мөнхдэлгэр Нийгмийн хамгаалал лекц. 2013 он., 3 хуудас.

³ Ц.Мөнхдэлгэр Нийгмийн хамгаалал лекц. УБ.,2013.

хэм хэмжээнд агуулагдах бөгөөд улмаар нийгмийн харилцааг зохицуулж байгаа үед чиг үүрэг болж тодорхойлогдох ба түүний тодорхой төрлийн харилцаа тус бүрд агуулагдана.

Нийгмийн хамгаалал нь нийгмийн даатгалтай холбогдсон оролцоогоор дамжуулан иргэдэд туслалцаа үзүүлж, эрхийг нь хамгаална. Иймээс нийгмийн хамгааллын зохицуулалтаас хамаарч түүний чиг үүрэг нь илрэн гарах ба үүнд, хэд хэдэн чиг үүргийг гүйцэтгэнэ.

Нийгмийн хамгааллын эдийн засгийн чиг үүрэг бол хамгийн чухал ба түүний мөн чанар нь, хуулинд заасан нөхцөл бүрдэх буюу эрсдэлд өртөн, өөрөө бий болгож байсан орлогын /цалин, хөлс, бусад орлого/ хэмжээ буурах үед түүнийг тодорхой түвшинд нөхөх зорилгоор төвлөрсөн хөрөнгийг дахин хуваарилах арга замаар илэрхийлэгдэнэ.

Нийгмийн хамгааллын нийгмийн чиг үүрэг нь хүний амьдрах эрхийн нэг ёсны баталгаа болох ба эрсдэлд өртөн хөдөлмөрийн чадвараа алдах, өтлөх, орлого багасан ядуурах, ажилгүй болох зэрэгт тэтгэвэр, тэтгэмж, нөхөн төлбөр олгон, туслалцаа үзүүлснээр нийгмийн гишүүн хүн нь бусад иргэдийн адилаар хөдөлмөрлөх, амьдрах нөхцлийг хангаж байдгаар илэрхийлэгдэнэ.

Нийгмийн хамгааллын улс төрийн чиг үүрэг нь төр, төрийн эрх мэдлийг барьж байгаа улс төрийн хүчин өөрсдийн баримтлаж буй нийгмийн бодлогоо нийгмийн хамгааллын системээр дамжуулан хэрэгжүүлж байдагтай холбогдон гарч байдаг.

Хүн ам зүйн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ нийгмийн хамгаалал нь хүн ам зүйн олон процесст нөлөөлөх, тухайлбал: хүн амын

амьдралын үргэлжлэл, наслалт, хүн амын нөхөн үржихүй, төрөлтийг дэмжих зорилгоор тэтгэвэр, тэтгэмж олгох, туслалцаа үзүүлдэг байна.


Монгол Улсад төрт ёс тогтсон үеэс иргэдийн нийгмийн хангамж үүссэн бөгөөд улс орны нийгмийн хангамжийн байгууллагаас хамаарч янз бүрээр шийдэгдэж ирсэн боловч Монгол Улсад ардын засаг тогтсоноос хойш улс орны эдийн засгийн хөгжлийн бололцоо нөхцөл бүрдэхийн хэрээр аажмаар хөгжиж ирсэн. Монгол Улсын нийгмийн хангамж нь иргэдэд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж төлбөр олгох эмнэлгийн үйлчилгээ эмчилгээний зардлыг хариуцан гаргах нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж, өндөр настан, тахир дутуу иргэдэд халамжийн тэтгэвэр олгох, төрөл бүрийн нийгмийн үйлчилгээнд хөнгөлөлт үзүүлэх, жирэмсний болон амаржсаны, олон хүүхэдтэйн тэтгэмж, нярайн хүүхдийн арчилгааны тэтгэмж, өнчин хүүхэд асрамжлах эмчлэх сувилах зэргээр иргэдийн амьжиргааг хангах эрүүл мэндийг хамгаалах талаар төрөөс авч хэрэгжүүлж буй нийгэм эдийн засгийн өргөн хүрээтэй асран тэтгэх шинжтэй нийгмийн хамгаалалын олон талт арга хэмжээ юм.

Нийгмийн халамжийн эдийн засгийн үүргийн хувьд хөдөлмөр эрхэлж байсан иргэд өндөр настай болох, хөдөлмөрийн чадвараа алдах, ажилгүй болох, хүүхэд төрүүлэх, асрах болон ахмад настан, тахир дутуу иргэд амжиргаагүй болох зэрэг нийгмийн үйлчилгээ шаардлагатай үед асран тэтгэх гол зорилготой.

Нийгмийн хамгааллын тогтолцоо

Монгол улсын нийгмийн хамгааллын тогтолцоо нь нийгмийн даатгал, нийгмийн халамж гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрддэг.

Зураг 1 Монгол Улсын нийгмийн хамгааллын тогтолцоо.



Нийгмийн даатгал нь иргэн /цаашид “даатгуулагч” гэх/ болон төр аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжинд байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх тухай арга хэмжээ юм. Иргэд дээр дурдсан тохиолдолд тэтгэвэр тэтгэмж авахын тулд хөдөлмөрийн чадвартай буюу ажил эрхэлж байхдаа нийгмийн даатгалд хуулиар тогтоосон шимтгэл төлж байдаг бөгөөд түүнээс үүссэн хуримтлалаар нийгмийн даатгалын сан бүрэлддэг.

Нийгмийн халамж нь: Бие даан амьдарч өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй, төрийн зүгээс зайлшгүй туслалцаа дэмжлэг үзүүлэх шаардлагатай бөгөөд дагаж мөрдөж буй даатгалын хуулиар тэтгэвэр тэтгэмж авах эрх үүсээгүй нийгмийн эмзэг бүлгийг төр ивээлдээ авч амьдрал ахуйд нь туслах шаардлагаас урган гардаг юм.

Нийгмийн халамжын арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төр хариуцдаг. Нийгмийн халамж гэж хүн амын эмзэг хэсэгт хамрагдах ахмад настан, эх хүүхэд, тахир дутуу иргэн, нэн ядуу амьдралтай иргэнд тэтгэвэр, тэтгэмж олгох, хөнгөлөлт үйлчилгээ үзүүлэх чиглэлээр тэдний амжиргааг дээшлүүлэх, түүнчлэн хүүхэд төрүүлсэн эх, бүтэн өнчин хүүхэд үрчлэн авсан эцэг эх болон ихэр

хүүхдэд тэтгэмж олгох тухай агуулга бүхий нийгмийн хамгааллын арга хэмжээг хэлнэ.

Нийгмийн халамж нь:

1. Нийгмийн халамжын тэтгэвэр, тэтгэмж
2. Нийгмийн халамжын болон асрамжын үйлчилгээ гэсэн хоёр үндсэн төрөлтэй, тус тусдаа бие даасан халамжын сантай бөгөөд хуулиар нийгмийн халамж, асрамжын үйлчилгээнд хамрагдах иргэдийн хүрээ, үйлчилгээний арга хэлбэрийг тодорхойлсон байдаг.

Хил хамгаалах байгууллагын албан хаагчдын нийгмийн асуудлыг дараах байдлаар ангилан авч үзлээ. Үүнд:

1. Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж; Үндсэн цалин, хилийн нэмэгдэл 5 жилд олгох болон нэг удаагийн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай. Харьцангуй таатай, тайван нөхцөлд ажиллаж байгаа багш, эмч, цагдаа бараг бүх төрийн байгууллагын албан хаагчид энэхүү нэмэгдэл урамшууллыг авч байна.

Хилчид Монгол Улсын хилийг тойрч, хөдөө зэлүүд алс газар алба хааж байгаад цэргийн тэтгэвэрт гарсаны дараа орон нутагтаа очиж суурьшихад амьдрах байр орон сууц байхгүй, авсан цалин урамшуулал нь хүүхдүүдийнхээ их дээд сургуулийн төлбөрийг төлөх хэмжээнд хүрэхгүй байна.

Цалин хөлс нь амьжиргаанд нь хүрэлцэж байгаа эсэх талаар судалгаа хийгдээгүй. Бусад төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтнуудын цалин хангамжаас хэт

доор болсон тохиолдолд боловсон хүчний дутагдалд орсон 1990-2000 оны алдаа давтагдахад хүрэхээр байна.

2. Хувцас хэрэглэлийн хангалт; Байгаль, цаг уур, бүсийн онцлогт тохирсон хувцас хэрэглэлээр хангах бодлого баримталж байна.

3. Ажлын байрны нөхцөл;

4. Эрүүл мэнд; Гадаадад эмчилгээ хийлгэх асуудал хууль тогтоомжид тусгагдсан байдаг боловч хязгаартай, шаардлагатай албан хаагч бүрт эмчилгээний зардал олгогдохгүй байна. Эрүүл мэндийн улмаас групп тогтоолгоход хувь хэмжээ бага тул амьдралын аргагүй байдлаас өвчнөө тэсвэрлэн ажиллаж байгаа олон хилчид байдаг. Хилчдийн дундаж наслалт, мэргэжлийн өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын талаар хийгдсэн судалгаа байдаггүй. Илүү цагаар, ачаалалтай ажилладаг, бүрэн нойр авдаггүй, хээрийн нөхцөлд ердийн хөсөгтэй үүрэг гүйцэтгэдэг зэрэг онцлогоос шалтгаалж хоол боловсруулах эрхтэн, нуруу, бөөрний өвчлөл зонхилдог. Хил хамгаалах байгууллагаас Улсын хил хамгаалалтыг хүний хүчээр зохион байгуулах бус автомашин техник, дохиолол-хяналтын систем нэвтрүүлэх бодлого сүүлийн үед зарим анги салбарт хэрэгжүүлж туршиж байна.

5. Хүүхдийн боловсрол, хувийн орон сууц;

6. Хилчид тэтгэвэрт гарсны дараа хийх ажилд мэргэшүүлэх сургалт;

7. Ахмад настны нийгмийн асуудал зэрэг асуудлууд байна.

Хил хамгаалах байгууллагаас энэ асуудалд анхаарч Хүний нөөцийн хэлтэст бие бүрэлдэхүүний нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтний орон тоог шинээр бий болгосон нь сайшаалтай юм.

Дүгнэлт

Нийгмийн хамгаалал гэдэг нь иргэдийнхээ нийгмийн нөхцөл байдлыг сайжруулах, эрсдэлд өртүүлэхгүйн тулд төрөөс хэрэгжүүлж буй арга хэмжээний цогц юм.

Нийгмийн даатгал гэдэг нь төр аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүнээс зохих журмын дагуу шимтгэл төлөх замаар сан бүрдүүлэн хуулиар тогтоосон субъектүүдэд тэтгэвэр, тэтгэмж, нөхөн төлбөр өгөх нийгмийн хамгааллын арга хэмжээ юм.

Нийгмийн халамж гэдэг нь төрийн зүгээс зайлшгүй туслалцаа дэмжлэг шаардлагатай, биеэ даан амьдрах чадваргүй нийгмийн эмзэг бүлгийг төр ивээлдээ авч тэтгэвэр тэтгэмж өгөх арга хэмжээ юм.

Хил хамгаалах байгууллагын албан хаагчдаас авсан социологийн судалгаа, бие бүрэлдэхүүний дунд зохион байгуулсан нээлттэй хэлэлцүүлэг болон бусад судалгаануудын үр дүнд үндэслэн хилийн цэргийн алба хаагчдын нийгмийн асуудлын өнөөдрийн байдлын талаар дараахь дүгнэлтийг хийж болохоор байна.

Хилчдийн дийлэнх нь албаны болон түрээсийн байранд амьдарч байгаа нь судалгаагаар харагдаж байна. Иймд аймаг орон нутгийн удирдлагуудтай хамтран бие бүрэлдэхүүнд газар олгох ажлыг эрчимжүүлэн, албан тушаалын орон сууцны хэрэгцээг нарийвчлан тооцож, бие бүрэлдэхүүнийг ипотекийн зээлд хамруулах зэрэг ажлыг үр дүнтэй зохион байгуулахад анхаарах хэрэгцээ шаардлага байна.

Хил хамгаалах албаны онцлогоос шалтгаалан хилийн цэргийн алба хаагчид гэр бүлийн хүнтэйгээ цуг ажиллах боломж хязгаарлагддаг байна. Үүнээс үүдэн өрхийн орлого доогуур, амьжиргаанд хүрэлцдэггүй нь судалгаагаар нотлогджээ.

Нийгмийн хамгаалал нэр томъёоны цаана халамжийн бодлого

биш, хилчдийн хөгжилд суурилсан ажлыг өрнүүлснээр зах зээлийн хямралын өнөөгийн нөхцөлд цаг үеэ олсон үр дүнтэй ажил болно гэсэнтэй бидний зүгээс санал нийлсэн. Хилийн цэргийн бие бүрэлдэхүүний тохитой тогтвортой ажиллах, өөрийгөө хөгжүүлэх орчин бий болгох, цэргийн албан хаагчдаас албаа сэтгэл хоёрдолгүй хаах нөхцөл боломжийг бүрдүүлэх, тэдний нийгмийн хамгааллыг хангах нь удирдлагын нэн чухал зорилт болж байна.

Санал

Нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах, эзэнд нь очих хүртээмжийг нэмэгдүүлэх, ядуурлаас гарахад дэмжлэг үзүүлэхэд чиглэж ажиллах;

Нийгмийн хамгааллын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгож, сум, хорооны түвшинд нийгмийн хамгаалал, асрамж, үйлчилгээг зохион байгуулах, нийгэм хамт олонд түшиглэсэн үйлчилгээг нэвтрүүлэх;

Хилийн цэргийн албан хаагчдыг амралт, сувилалд хөнгөлөлттэй үнээр амраах асуудлыг шийдвэрлэх, хүн эмнэлгийн албаны үйлчилгээний нэр төрөл, чанарыг дээшлүүлэхэд анхаарах;

Хилчдийн нийгмийн хамгааллыг сайжруулахын тулд нэн тэргүүнд цалин хангамжыг нэмэгдүүлэх, орон байрны асуудлыг шийдэх, хилчдийн хүүхдүүдийн боловсролын асуудалд анхаарах зэрэг болно.

Эх сурвалжийн жагсаалт

- С.Энхцацрал, Нийгмийн хамгаалалын эрх зүйн лекцүүд.Уб.,2011.

- Ц.Мөнхдэлгэр Нийгмийн хамгаалал лекц.Уб.,2013.

- А.Амартайван. Хил хамгаалах байгууллагын албан хаагчдын нийгмийн хамгааллыг боловсронгуй болгох арга зам.Уб.,2015.